ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ: Товч танилцуулга

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, хариуцлагатай, чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн 2024-2030 онд хэрэгжих дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлан эрсдэлийг бууруулах, ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлэх цогц ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан явуулж, ёс зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэснээр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааны үр дүн сайжирч, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёл хэвшин, төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

ХОЁР: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Авлигатай тэмцэх газартай хамтран соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагчдыг авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс сургалт зохион байгуулж, мөн байгууллагын цахим хуудаст авлигын эсрэг нэгдэх, хор нөлөөг сурталчилсан баннер, мэдээллүүдийг тухай бүр байршуулсан.

Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан "Төрийн болон албаны нууц, түүний хамгаалалтын тухай" сургалтанд байгууллагын 23 албан хаагч хамрагдсан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 тушаалаар Ёс зүйн дэд хороо байгуулсан.

Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг газрын даргын 2025 оны өдрийн А/86 дугаар тушаалаар баталсан.

2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 тушаалаар Ёс зүйн дэд хороо байгуулж 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд “Ёс зүйн зөрчлийн бүртгэл хяналт” дэд системд ёс зүйн дэд хорооны мэдээллийг бүртгэж баталгаажуулсан.

Монгол Улсын Ёс зүйн хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.9.-д ... судалгаа ... албан тушаалтнаас гаргуулан авах, Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.2.1-т "төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг жил бүр зохион байгуулж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшинэ." гэсэн заалтын дагуу:

- "Төрийн албан дахь ёс зүйн зөрчил шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг тандах судалгаа"-ны ажлын хүрээнд цахимаар өгөгдөл цуглуулах иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа"-г 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулсан тус судалгаанд байгууллагын 34 албан хаагч, 30 иргэний судалгааг авч хүргүүлсэн.
- Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний судалгааг байгууллагын 28 албан хаагчаас авч нэгтгэн тайлагнасан.
- Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, зарчмын талаар "Өглөөний кофе" сургалт арга хэмжээг зохион байгуулж явуулсан.
- Тус байгууллагад шинээр томилогдон ажиллаж байгаа 8 албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг танилцуулан зөвлөмж өгч ажилласан.
- Төрийн албаны зөвлөлийн "7:4:10" сургалтуудад байгууллагын албан хаагчид хамрагдсан.
- Байгууллагын цахим хуудсаар болон бусад хэлбэрээр төрийн албаны тухай хууль, авлига ашиг сонирхлоос ангид байх зэрэг 8 удаагийн мэдээллийг хүргэж ажилласан.

Төрийн албан хаагчдаас ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг, эрхэлсэн асуудлын хүрээнд байгууллага, нэгжийн удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, ажил үүрэгтэй холбоотой алдаа дутагдал болон хөдөлмөрийн маргаан, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудал 2025 онд бүртгэгдээгүй.

Санал:

Хөдөлмөрийн хуулийн 38 дугаар зүйлд "Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал" гэх зэрэг заалтаар ажлын орчны сэтгэл зүйн эрүүл мэндэд халгүй байх нөхцөлийг хангах үүрэгтэй гэж, Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлд төрийн албан хаагчдын сахилга, ёс зүйн талаар зааж, төрийн албанд ажиллахад сэтгэл зүйн болон эрүүл мэндийн шаардлага хангасан байх шаардлагатай тухай, Эрүүл мэндийн тухай хуульд төрийн албан хаагчдын эмнэлгийн үзлэг, сэтгэл зүйн шинжилгээ, үзлэгүүдийг үе үе хийж байх шаардлагатай байж болно гэж заасан бол "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод төрийн албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар тодорхой заалт байхгүй боловч, нийтлэг урт хугацааны зорилтууд болон төрийн албаны хөгжил, чадавхыг сайжруулах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх талаар дурдсан хэдий ч төрийн албан хаагчид сэтгэл зүйн тулгамдсан асуудалдаа тусламж, үйлчилгээ авч чадахгүй байгаа бөгөөд одоогийн нийгэм бүх төрийн албан хаагчдыг сэтгэл зүйн дархлаатай байхыг шаардаж байна.

Төрийн албан хаагчийн стресс, түгшүүр, санаа зовних, ажлаас халшрах хам шинж, сэтгэл гутрал зэрэг сэтгэл зүйн тулгамдсан нийтлэг асуудлыг хамгаалах үр ашигтай тогтолцоог бий болгож, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудалд нөлөөлөх нөлөөллийг шат дараатай системтэй үр дүнтэй зохион байгуулан төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.БАТХОРОЛ

2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 05

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛД ӨРТӨХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

№	Эрсдэлийн хүрээ	Эрсдлийн агуулга	Магадлал	Нөлөөлөл
А.Төрийн албан хаагч өөрийн чиг үүргийн хүрээнд ажиллахад тулгамдаж буй асуудал бэрхшээлийг тодорхойлох хэсэг				
1	Албан тушаалын эрх мэдэл шийдвэр гаргалт	1.1 Шийдвэр гаргах, нөлөө бүхий эрх мэдэлтэй	57	65
		1.2. Иргэд, аж ахуйн нэгжид шууд нөлөөлөх шийдвэр гаргадаг (зөвшөөрөл, лиценз, үнэлгээ, шалгалт)	65	62
		1.3.Гадаадын төсөл, хөтөлбөртэй харилцдаг	47	45
		1.4. Хүний нөөцийг томилох, дэвшүүлэх, сургаж хөгжүүлэх, шагнаж урамшуулах эрх мэдэлтэй	47	49
2	Мэдээлэл ашиглах, нууцад хандах эрх	2.1.Санхүү төсөв, тендертэй холбоотой мэдээлэлтэй ажилладаг	60	55
		2.2.Төрийн болон албаны нууц, иргэдийн хувийн мэдээлэлд нэвтрэх эрхтэй	70	62
		2.3.Албан хэрэгцээнд зориулсан мэдээлэл, өгөгдөл цуглуулах, хэрэглэх	97	75
3	Ёс зүйн мэдлэг, дадал	3.1.Ёс зүйн хууль тогтоомжтой танилцуулдаг	73	66
		3.2.Ёс зүйн сургалт, хөтөлбөрт хамруулсан	72	60
		3.3.Суургалтаар олсон мэдлэгийг ажилдаа хэрэгжүүлэх дадал суулгадаг	75	70
		3.4. Ёс зүйн асуудал тулгарсан үед хаана хэнд хандах нь	80	65
4	Иргэдтэй харилцах байдал	4.1.Иргэдтэй нүүр тулж харилцдаг	100	75
		4.2.Сэтгэл хөдлөл ихтэй сэтгэл зүйн ачаалал өндөр	74	63
		4.3.Санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллах хандлага тааруу	64	67
		4.4.Шүүмжлэлд эмзэг, мэдрэмтгий	62	60
Б.Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдолд буй бэрхшээлийг тодорхойлох хэсэг				
5	Ашиг сонирхлын зөрчил	5.1.Асуудлыг танил тал найз нөхдийн хүрээллээр шийддэг	46	56
		5.2. Шийдвэр гаргахад гадны бусад нөлөөлөл их	47	56
6	Удирдах албан тушаалтны манлайлал	6.1.Ёс зүйн хэм хэмжээг мөрддөгүй зөрчлийг үл тоодог	51	60
		6.2.Ёс зүйн сургалтанд хамрагддагүй	60	65
		6.3. Удирдлагын шийдвэр гаргалт шударга бус	57	67
		6.4.Хүний нөөцийн бодлого шударга бус	64	70
		6.5. Ёс зүйн хариуцлагаас зайлсхийдэг	48	54
		6.6.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дэмждэггүй	54	63
7	Ил тод байдал ба тайлагнал	7.1.Ажлаа хугацаанд нь тайлагнадаггүй	49	59
		7.2.Иргэд олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангадаггүй	46	53
		7.3.Ёс зүйн хариуцлагын талаар мэдээлдэггүй	49	59
8	Үүрэг хариуцлага сахилга	8.1.Үүрэгт ажлыг хугацаанд нь биелүүлдэггүй	45	56
		8.2.Өмч хөрөнгө техник хэрэгслийг зөв ашигладаггүй	45	54
		8.3.Дотоод зөрчил, маргааныг шийдэх тогтолцоо бэхжээгүй	55	66
9	Байгууллагын соёл	9.1.Хамт олны дунд уур амьсгал сөрөг	55	65
		9.2.Байгууллагын үйл ажиллагаанд оролцоог хангадаггүй	55	62
		9.3.Ялгаварлал гадуурхалтыг тэвчихгүй, мэдээлдэггүй	53	64
		9.4.Гомдол мэдээлэх авах тогтолцоо бүрдээгүй	52	60

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 01-ний
өдрийн 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх		1	1	37
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үлй ажиллааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	
Хэсгийн оноо				**4**	**4**	
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх (гарсан дүгнэлтийг хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	37
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	
Хэсгийн оноо				**3**	**3**	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал (Гомдол ирээгүй бол 1 оноо авна нийт ирүүлсэн өргедөл гомдлыг хувийн жингээр тооцно)		1	1	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл хяналтын дэд систем дэх дүгнэлт шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	1	
Хэсгийн оноо				**3**	**3**	
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**10**	

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Б.ЦЭНД

2025 оны 02 дугаар сарын 03

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах албан хаагч
1	Ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж батлуулах, биелэлтийг тайлагнах	II IV улиралд	Төлөвлөгөө батлуулж биелэлтийг журмын дагуу тайлагнана.	Дэд хорооны гишүүд
2	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах	II улиралд	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.	Дэд хорооны гишүүд
3	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээний хүрээнд зураг дүрс бичлэг, цахим хэлбэрээр танилцуулга мэдээлэл бэлтгэж албан хаагчдыг мэдээллээр хангаж ажиллах /Подкаст, постер, видео контент/	Тухай бүрт	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага дээшилнэ.	Дэд хорооны гишүүд
4	Албан хаагчдыг болон Шинээр томилогдсон албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийг танилцуулах, зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах	Тухай бүрт	Хууль тогтоомжийг сурталчлан таниулна.	Дэд хорооны гишүүд
5	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх арга хэмжээг хэрэгжүүлэх	I улиралд	Бодлого, шийдвэр, ажлын уялдааг хангах, хууль тогтоомжийн нийцлийг сайжруулна.	Дэд хорооны гишүүд
6	Ёс зүйн дэд хорооны гишүүдийг Ёс зүйн зөвлөл, холбогдох байгууллагаас зохион байгуулагдах сургалтад хамруулах	Тухай бүрт	Холбогдох сургалтанд хамрагдана.	Дэд хорооны гишүүд
7	Албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчил, өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх, тэмдэглэл хөтлөх	Тухай бүрт	Цаг тухай бүрт нь бүртгэж гишүүдийг мэдээллээр хангана.	Нарийн бичгийн дарга
8	Ёс зүйн Зөрчил, өргөдөл гомдлыг судлах, дүн шинжилгээ хийх, шалтгааныг тогтоон зөвлөмж, дүгнэлт гаргаж тайлагнах	Тухай бүрт	Зөрчил, өргөдөл гомдлыг үнэн зөв тогтооно.	Дэд хорооны гишүүд

9	“Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд зөрчлийг бүртгэх	Тухай бүрт	Гомдол, мэдээллийг хүлээн авч, зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргана.	Нарийн бичгийн дарга
10	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлт ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх шийдвэрлэлтийн мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээлэх,	Тухай бүрт	Иргэд,олон нийтийг ил тод мэдээллээр хангана.	Нарийн бичгийн дарга
11	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх	Тухай бүрд	Тайлан мэдээ цаг хугацаанд нь тайлагнаж мэдээлнэ.	Нарийн бичгийн дарга
12	Ёс зүйн дэд хорооны холбогдох баримт бичгүүдийг архивын нэгж үүсгэн албан хэрэг хөтлөлтийн хууль журмын дагуу баримт материалыг архивд хүлээлгэн өгөх	IV улиралд	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бичгийг хүлээлгэн өгсөн байна.	Нарийн бичгийн дарга

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ГИШҮҮН Д.БАТХОРОЛ